



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/34/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс: 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Э.АМГАЛАНБАЯР ТАНАА 7

2020.08.27 № 1/206

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020160



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дарга Э.Амгаланбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 23-нээс 2020 оны 01 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дах Төрийн аудитын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 140 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Өндөр сумын ЗДТГ нь "Байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шударга хүртээмжтэй болгох бодит шаардлагыг стратеги төлөвлөгөө боловсруулах явцад харгалзан үзэж, зохион байгуулалтыг оновчтой болгох, хамт олны нийтэч эв нэгдэлтэй байдлыг хангах замаар, иргэдэд соёлтой, шуурхай үйлчлэх шилдэг боловсон хамт олныг бүрдүүлэх явдал юм" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг "Төрийн бүх шатны суурь үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай мэргэжлийн үүднээс хэргэх явдал" гэж тодорхойлжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баян-Өндөр сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Өндөр сумын ЗДТГазар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ын "Acoulous" программ хангамж ашигладаг байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Өндөр сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 500204,1 мянган төгрөгөөс тооцон 10004,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 500204,1 мянган төгрөгөөс тооцон 10004,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Өндөр сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 433818,7 мянган төгрөгөөр буюу 33,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	26,816.3	29,120.4	2,304.1
Үндсэн хөрөнгө	2,748,080.9	3,131,051.1	382,970.2
Хуримтлагдсан элэгдэл	-1,478,588.0	-1,430,043.5	48,544.5
Нийт хөрөнгө	1,296,309.3	1,730,128.0	433,818.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,296,309.3	1,730,128.0	433,818.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,296,309.3	1,730,128.0	433,818.7

Бараа материалын дансны үлдэгдэл 2304,1 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал өссөнтэй холбоотой байна. Энэ нь бусад хангамжийн материалд 1820,0 мянган төгрөгийн өртөгтэй стандарт жорлон, 540,0 мянган төгрөгийн өртөгтэй туузан гэрэлтүүлэг орлого авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 382,970.2 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018 онд ашиглалтад орсон 470000,0 мянган төгрөгийн өртөгтэй спорт заалыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 17 дугаар тогтоолоор, төсвийн хөрөнгөөр 17388,0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, мөн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 11 сарын 29 өдрийн 14/06 дугаар тогтоолоор 185550,0 мянган төгрөгийн ЗДТГ-ын конторын барилгыг худалдсан, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 05 сарын 19-ны өдрийн 14 дугаар тогтоолоор 521,2 мянга, 2019 оны 05 сарын 19-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 543,5 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,730,128.0 мянган төгрөг болж 433,818.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 431,318.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт зориулан сумын ИТХ-ын 2018 оны 12 сарын 17-ны өдрийн 10/04 дугаар тогтоолоор 337124,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 337124,9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 337124,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 326236,1 мянган төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь 13158,8 мянган төгрөгийг хэмнэж буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Үүнээс Цалин НДШ-ийн зардлыг 6353,1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 842,7 мянга, гэрэл цахилгааны зардлыг 482,0 мянга, томилолт зочны зардал 1170,0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хөлс 1400,0 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд 2018 оны үлдэгдлээс санхүүжүүлэх 21889,1 мянга, малжуулах зээлийн эргэн төлөлт 4658,0 мянга, нөхөн сэргээлтийн барьцаа байршуулсан 1000,0 мянга, Хүүхэд гэр бүл хөгжлийн газраас хамтарсан багийн санхүүжилт 1500,0 мянга, Эрдэнэ монгол ХХК-аас 5000,0 мянга, цахим тендерийн хураамж 198,0 мянга, Аймгийн Засаг даргын 2019 оны 01 сарын 23-ны өдрийн А/13 дугаар захирамжаар 2018 оны ажлын үр дүнгээр тэргүүний сумын шалгарсан сумын шагналын мөнгө 9970,0 мянга, малын сэг зэм устгах зардал 1720,0 мянган төгрөг нийт 32555,0 мянган төгрөгийн орлого орж 18178,9 мянган төгрөг зарцуулж 14376,1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 35 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 29 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар дараах 2500,0 мянган төгрөгийн алдааг залруулж санхүүгийн тайланд тусгалаа.

1.Балансын данстай холбоотой

1.1 Илрүүлэлт

Баян-Өндөр сумын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлөөс 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хилийн 0203 дугаар салбарт хилийн манааны уналгын 2500,0 мянган төгрөгийн өртөгтэй мотоцикл өгсөн байна. Үүнийг үндсэн хөрөнгөндөө бүртгэж аваагүй байна.

1.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үрэгдэх шавшигдах

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөнд бүртгэж залруулав

Аудитаар нийт 4044,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 194,8 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 3850,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3850,0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	194,8	
3	Албан шаардлага өгсөн	1		
	Дүн	5	4044,8	

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар дараах 4044,8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 194,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд

1. Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны 01 сарын 23-ны өдрийн А/13 дугаар захирамжаар тэргүүний сумаар шалгарсан сумын Засаг даргад 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоходоо ХАОАТ суутгалгүй 1948,5 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Хүн амын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно" 6.3.1-т "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан Монгол улсад орж ирсэн гаалийн бичигтэй боловч хог тээврийн автомашин нь ЗДТГ-ын эзэмшилд бүртгэгдээгүй Ганбаяр гэсэн иргэний нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.1 дэх "Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам-ын 3.5.5-д "Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа энэ журмын дол дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу акт үйлдэж тамга тэмдэг, дарж баталгаажуулна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баян-Өндөр сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 124 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй /Хугацаа болоогүй/
1	Бүтэн жил	11	11	4	2	5
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	32	4	
5	Тухай бүр	8	96	80	16	
6	Нийт	27	151	124	22	5

Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс 4 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 3 мэдээллийг байршуулаагүй байна. Хугацаа хоцроосон дараах мэдээллүүд байна. Үүнд:

- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл
- Аудитын тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Байршуулаагүй дараах мэдээллүүд байна.

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан
- Хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалтын тайлан

Хугацаа болоогүй дараах мэдээллүүд байна.

- Санхүүгийн тайлан
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

Сар бүр мэдээлэх 36 мэдээллээс 32 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Хугацаа хоцроосон 4 мэдээлэл нь:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /5 сар,9 сар/
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл / 5 сар/
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт / 5 сар/

Тухай бүр мэдээлэх 96 мэдээллээс 80 мэдээллийг хугацаанд нь 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд :

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ /2 сар,3 сар,4 сар, 6 сар, 8 сар,9 сар/
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /2 сар/
- Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг /2-9 сар хүртэл/

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Өндөр сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй архивын программ 200,0 мянга, багийн санхүүгийн программ 150,0 мянган төгрөгийн программ хангамжид бүртгэлтэй ашиглалтгүй хөрөнгүүд байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн Үнэн зөв байх зарчмыг баримтална" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1.2 Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

1.1.3 Өгсөн зөвлөмж

Ашиглалтгүй байгаа программ хангамжуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1.1 Илрүүлэлт:

Тухайн байгууллагад 2941БНХ дугаартай UAZ3909, 9808БНХ дугаартай Land 105, 2971БНХ дугаартай UAZ2206692, 2637БНХ Хот тохижилтын машин гэсэн автомашинууд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаагаас 2637БНХ хог тээврийн зориулалттай машин, 2971БНХ дугаартай пургон автомашин ашиглалтгүй байгааг тодруулахад нягтлан бодогч машинуудын сэлбэг олдохгүй байгаа учир ашиглахгүй байгаа талааргэсэн тайлбар өглөө

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.5.1.4 Үнэн зөв байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Ашиглалтгүй үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Ашиглалтгүй байгаа 39500,0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 автомашиныг ашиглалтад оруулах болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3 *Зардлын данстай холбоотой асуудал*

3.1.1 Илрүүлэлт:

Сумын ЗДТГ-ын дарга Э.Амгаланбаяр БНХАУ явахдаа сумын Засаг даргын 2019 оны 10 сарын 22-ны өдрийн А/70 дугаар захирамжаар ЗДТГ-ын төсөвт гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад гадаад арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр шийдвэр гаргуулж 1000,0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтын “Бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангилал, Төсвийн тухай хуулийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв хэтрүүлэн зарцуулах

2.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шаардлагатай нөхцөлд төсвийн зардал хооронд зохицуулалт хийсэн нөхцөлд зардлыг санхүүжүүлж, гарсан зардлыг нягтлан бодох бүртгэлд зөв ангиллаар тайлагнах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,816,344.00</u>	<u>29,120,404.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	26,816,344.00	29,120,404.00
354	Хангамжийн материал	24,063,544.00	27,870,404.00
35410	Бичиг хэргийн материал	708,000.00	468,000.00
35420	Аж ахуйн материал	66,500.00	362,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,289,044.00	27,040,404.00
35600	Мал амьтад	2,752,800.00	1,250,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,269,492,916.64</u>	<u>1,701,007,605.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,269,492,916.64	1,701,007,605.26
392	Биет хөрөнгө	1,226,710,374.83	1,658,313,605.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,254,638,376.29	2,587,785,196.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,226,936,042.64	-1,149,343,633.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,624,800.00	153,124,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,135,833.08	-67,604,166.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	214,307,612.00	221,773,612.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-147,176,075.80	-157,294,125.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,681,001.00	64,009,851.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,226,916.53	-37,391,598.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,000,000.00	38,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,416,666.41	-16,624,999.89
39217	Ном	22,350,120.00	21,878,670.00
393	Биет бус хөрөнгө	42,782,541.81	42,694,000.00
39301	Програм хангамж	1,785,000.00	1,785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,696,458.19	-1,785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,694,000.00	42,694,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,296,309,260.64</u>	<u>1,730,128,009.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,296,309,260.64</u>	<u>1,730,128,009.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,296,309,260.64	1,730,128,009.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,032,910.00	693,032,910.00
51101	Өмч: - төрийн	693,032,910.00	693,032,910.00
512	Хуримтлагдсан үр дүн	383,446,863.79	892,821,098.17
51210	Өмнөх үеийн үр дүн	383,446,863.79	459,002,349.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,829,486.85	144,274,001.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,296,309,260.64</u>	<u>1,730,128,009.26</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	508,073,429.00	934,022,810.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,946,230.00	550,566,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,946,230.00	550,566,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,946,230.00	550,566,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,020,000.00	870,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,926,230.00	549,696,820.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,127,199.00	383,455,990.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,744,590.00	46,931,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,744,590.00	7,572,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	21,889,090.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,231,000.00	336,524,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	378,231,000.00	336,524,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,151,609.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,151,609.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	461,193,156.34	446,644,693.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,193,156.34	446,644,693.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,765,112.34	390,297,791.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,176,902.00	178,486,921.00
210101	Үндсэн цалин	173,176,902.00	178,486,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,671,602.00	22,025,478.00
210201	Тэтгэврийн даатгал	13,942,147.00	15,212,228.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,753,370.00	1,797,669.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,387,335.00	1,438,134.00
210204	Ажилгүйдлийн даатгал	326,250.00	325,222.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,262,500.00	3,252,225.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,075,821.00	14,121,324.00
210301	Гэрэл, цахилгаан	1,773,221.00	2,319,324.00
210302	Түлш, халаалт	14,302,600.00	11,802,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,619,980.00	28,512,200.00
210401	Бичиг хэрэг	3,943,400.00	2,760,300.00
210402	Тээвэр, шатахуун	26,080,990.00	21,508,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	114,990.00	1,116,000.00
210404	Ном, хэвлэл	9,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,700.00	803,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,236,600.00	2,324,300.00
2105	Нормативт зардал	410,905.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	410,905.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,530,650.00	3,576,159.00
210604	Урсгал засвар	4,530,650.00	3,576,159.00
2107	Томилолт, зочны зардал	6,202,000.00	11,615,511.00
210702	Дотоод албан томилолт	6,202,000.00	6,317,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,398,060.00	37,261,735.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,324,860.00	34,546,845.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,936,200.00	2,714,890.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	137,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,679,192.34	94,698,463.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,332,700.00	10,117,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	312,000.00	70,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,034,492.34	84,510,763.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,428,044.00	56,346,902.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,000,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,000,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,474,709.00	28,812,032.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,151,609.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,323,100.00	25,365,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	63,953,335.00	27,534,870.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,344,245.00	13,158,780.00
213404	Хөрөнгийн	23,609,090.00	14,376,090.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,880,272.66	487,378,117.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,447,817.09	53,559,368.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,289,785.38	53,559,368.38
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	7,158,031.71	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,447,817.09	-53,559,368.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,432,455.57	433,818,748.62

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	465,147,199.00	388,365,886.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,020,000.00	870,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,020,000.00	870,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,020,000.00	870,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,020,000.00	870,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,127,199.00	387,495,886.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,744,590.00	46,931,090.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	17,470,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,744,590.00	7,572,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	21,889,090.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,231,000.00	336,524,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	378,231,000.00	336,524,900.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,151,609.00	4,039,896.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	465,147,199.00	368,477,886.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,147,199.00	368,477,886.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,732,885.00	308,137,888.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,176,931.00	178,418,958.00
210101	Үндсэн цалин	163,288,044.00	174,615,203.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,888,887.00	3,803,755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,671,573.00	22,093,441.00
210201	Тэтгэврийн даатгал	16,692,003.00	15,138,598.00
210202	Тэтгэмжийн даатгал	785,766.00	1,797,670.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	455,621.00	1,438,134.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118,152.00	325,223.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,620,031.00	3,393,816.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,262,971.00	16,557,324.00
210301	Гэрэл, цахилгаан	1,773,221.00	2,563,324.00
210302	Түлш, халаалт	14,489,750.00	13,694,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,267,500.00	24,812,670.00
210401	Бичиг хэрэг	2,892,400.00	2,494,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,114,610.00	20,634,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,660.00	858,770.00
210404	Ном, хэвлэл	109,830.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	224,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	600,000.00
2105	Нормативт зардал	106,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	106,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,499,150.00	7,042,110.00
210602	Тавилга	00.00	765,000.00
210604	Урсгал засвар	5,499,150.00	6,277,110.00
2107	Томилолт, зочны зардал	6,202,000.00	9,685,360.00
210702	Дотоод албан томилолт	6,202,000.00	6,317,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	3,368,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,971,460.00	38,106,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,866,400.00	35,103,169.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,105,060.00	3,002,956.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,575,300.00	11,421,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,975,300.00	11,321,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,414,314.00	60,339,998.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	42,986,270.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	42,986,270.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,474,709.00	32,805,128.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,151,609.00	4,039,896.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,323,100.00	25,365,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,399,732.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	63,953,335.00	27,534,870.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,344,245.00	13,158,780.00

213404	Хөрөнгийн	23,609,090.00	14,376,090.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	19,888,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	19,888,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	19,888,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	19,888,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	19,888,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-19,888,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,338,910.00	134,757,713.92	1,253,141,855.22	2,038,238,479.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,338,910.00	134,757,713.92	1,253,141,855.22	2,038,238,479.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-152,757,871.63	-152,757,871.63
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,032,910.00	219,829,486.85	383,446,863.79	1,296,309,260.64
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,032,910.00	219,829,486.85	383,446,863.79	1,296,309,260.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	75,555,485.76	75,555,485.76

	бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,032,910.00	219,829,486.85	459,002,349.55	1,371,864,746.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-75,555,485.76	00.00	-75,555,485.76
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	433,818,748.62	433,818,748.62
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,032,910.00	144,274,001.09	892,821,098.17	1,730,128,009.26

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны /төгрөг/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	337,124,900.00	324,236,120.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,124,900.00	324,236,120.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,359,400.00	283,970,888.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,819,900.00	178,418,958.00
210101	Үндсэн цалин	178,619,900.00	174,615,203.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,200,000.00	3,803,755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,045,600.00	22,093,441.00
210201	Тэтгэврийн даатгал	15,612,800.00	15,138,598.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,858,200.00	1,797,670.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,486,500.00	1,438,134.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,700.00	325,223.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,716,400.00	3,393,816.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,882,000.00	16,557,324.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,300.00	2,563,324.00
210302	Түлш, халаалт	14,536,700.00	13,694,000.00
210304	Байрны түрээс	300,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,926,600.00	24,812,670.00
210401	Бичиг хэрэг	2,427,200.00	2,494,800.00
210402	Тээвэр, шатахуун	20,702,000.00	20,634,400.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	897,400.00	858,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	224,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,777,200.00	15,430,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,300,000.00	3,920,000.00
210602	Тавилга	5,000,000.00	5,233,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	6,277,200.00	6,277,110.00
2107	Томилолт, зочны зардал	10,855,900.00	9,685,360.00
210702	Дотоод албан томилолт	6,855,900.00	6,317,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	3,368,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,952,200.00	5,551,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,948,200.00	2,548,169.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,004,000.00	3,002,956.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,100,000.00	11,421,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	11,321,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,176,500.00	4,026,523.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,000,000.00	11,500,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,000,000.00	11,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,765,500.00	28,765,232.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,365,500.00	25,365,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400,000.00	3,399,732.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	337,124,900.00	324,236,120.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	336,524,900.00	323,366,120.00
132001	Орон нутгийн төсвөөс	336,524,900.00	323,366,120.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	870,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	870,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	05.00	05.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,555,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,555,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,555,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,555,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,555,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32555000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,555,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,435,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,378,000.00
131106	Төсвийн урамшуулал	17,742,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: *Н.Бунчинсүрэн* Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.Цээням* А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ 2020.02.25